



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 297,000,000.00 (хоёр зуун ерэн долоон сая) төгрөгийн балансын үнэ, 100,237,500.00 (нэг зуун сая хоёр зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Алтангэрэл, “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж (Улсын дугаар “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт хадгалагдаж үлдэнэ), арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005855
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2023 оны ... дугаар сарын ... өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)

Д/д	Автомашинны нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд крузейр-J200 (арлын дугаар- JTMHXO5J705103645)	2020/2021	ш	1	297,000,000.00	100,237,500.00	196,762,500.00
Нийт дүн						100,237,500.00 (нэг зуун сая хоёр зуун гучин долоон мянга таван зуун)	(нэг зуун ерэн зургаан сая долоон зуун жаран хоёр мянга таван зуун)